330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,821.20	15,027.50
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	52,025.40	75,254.58
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000.00	74,937.04
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	317.53
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	32,025.40	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	62,897.56
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	107,590.74

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	284,509.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	284,509.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	254,947.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,788.09
210101	Үндсэн цалин	456.00
210104	Урамшуулал	20,874.09
210105	Гэрээт ажлын хөлс	3,458.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,054.40
210401	Бичиг хэрэг	4,235.78
210402	Тээвэр, шатахуун	6,392.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	416.50
2105	Нормативт зардал	67,898.55
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,657.89
210502	Хоол, хүнс	3,799.09
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,441.57

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	142,825.14
210601	Багаж, техник, хэрэгсэл	75,003.30
210602	Тавилга	11,300.00
210604	Урсгал засвар	56,521.84
2107	Томилолт, зочны зардал	338.26
210702	Дотоод албан томилолт	338.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,947.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,947.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,096.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,096.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,561.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,161.26
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5.26
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,156.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285,386.17
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285,386.17
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,350.00
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,198.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,255.07
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	193,583.10
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	877.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	877.16

Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ц.Гансүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 15 -аас 2022 оны 3 дугаар сарын 25 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа, аудитын менежер Г.Даваа нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Ганцэцэг гүйцэтгэв.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдөр 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Санхүү үйл ажиллагааны эрхэм зорилго нь санхүүгийн сахилга батыг чандлан сахиж, татварын орлогын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүүгийн оновчтой удирдлагаар хангахад оршино.” гэж тодорхойлсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Асгат сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдахгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрэх магадлалтай байна.

2021 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна. Асгат сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт 2,173,122.5 мянган төгрөгийн зардлын 1 хувь буюу 21,731.2 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 158608.9 мянга, эцсийн үлдэгдэл 284983.3 мянган төгрөг болж, 126374.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	158,255.7	286,082.9	127,827.2	99.4
Банканд байгаа бэлэн мөнгө	353.2	761.5	408.3	0.3
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0	877.2	877.2	0.3
Дүн	158,608.9	287,721.5	129,112.7	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 286,082.9 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 761.5 мянган төгрөг арилжааны банкны дансанд, 877.2 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 128,039.7 мянга, эцсийн үлдэгдэл 201,407.2 мянган төгрөг болж, 73,367.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбоотой авлага	0	611.1	611.1
Байгууллагаас авах авлага	157.0	102,635.9	102,478.9
Хувь хүмүүсээс авах авлага	127,882.7	98,160.1	-29,722.6
Дүн	128039.7	201,407.2	73,367.4

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн 98,096.9 мянга, ЭМТ-ийн цар тахалтай холбоотой үүссэн авлага 100,839.5 мянга, бусад авлага 2,470.9 мянган төгрөг байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 90,669.8 мянга, эцсийн үлдэгдэл 210148.3 мянган төгрөг болж, 119478.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	8,528.4	9,495.3	966.9
Эм боох материал	5,617.5	35,239.6	29,622.1
Бичиг хэргийн материал	1,388.6	5,344.1	3,955.5
Аж ахуйн материал	31,717.5	36,432.5	4,715.0
Түлш тослох материал	4,062.7	6,277.1	2,214.4
Барилгын засварын материал	85.0	299.0	214.0
Хүнсний материал	4,947.6	4,956.9	9.3
Бусад хангамжийн материал	15,297.4	92,198.6	76,901.2
Мал амьтад	19,024.9	19,904.9	880.0
Бусад нөөц	57,900.4	1,219.0	-56,681.4
Дүн	148,570.4	211,367.4	62,797.0

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдлийн 43.6 хувийг бусад хангамжийн материал эзэлж байгаа бөгөөд аж ахуйн материал 17.2 хувь, мал амьтад 9.4 хувь, эм боох материал 16.7 хувь зэрэг нь үлдэгдэлд гол нөлөөлж байна.

Аудитын илрүүлэлт:

-Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэлтэй зөрчил илэрч зөвлөмж өгөв. /ЗДТГ, ИТХ/

-Бараа материалын тайланд 5.0 сая төгрөгийн дансны үнэтэй 45 хуц бүртгээгдсэн боловч бодитоор байхгүй зөрчил илэрч зөвлөмж хүргүүлэв. /ЗДТГ/

-Нэг аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 0.6 сая төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгээгдээгүй, И баримтаар нотлогдохгүй зөрчил дутагдал илэрч, албан шаардлага хүргүүлэв. /Ерөнхий боловсролын сургууль/

-Байгууллагын жилийн эцсийн тооллогоор 1.3 сая төгрөгийн түлш шатах тослох материалын үлдэгдэл, 1.0 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлд тооллого хийгдээгүй зөрчилд зөвлөмж хүргүүлэв. /Ерөнхий боловсролын сургууль/

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,497,258.1 мянга, эцсийн үлдэгдэл 4,789,125.0 мянган төгрөг болж, 291,866.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	3,286,563.9	3,341,335.6	54,771.7
Тээврийн хэрэгсэл	215,024.2	270,496.6	55,472.5
Машин тоног төхөөрөмж	394,395.6	470,796.4	76,400.8
Тавилга эд хогшил	246,475.1	270,963.6	24,488.5
Номын фонд	25,113.4	26,830.9	1,717.5
Бусад үндсэн хөрөнгө	279,817.5	343,709.6	63,892.1
Программ хангамж	3,497.5	3,797.5	300.0
Бусад биет бус хөрөнгө	46,370.6	61,194.6	14,824.0
Дүн	4,497,258.1	4,789,125.0	291,866.9

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 122,224.9, улс, орон нутгийн төсвийн хөрөнгийн санхүүжилтээр үнэ төлбөргүй бүртгэсэн 74,183.6, шилжүүлэн авсан 128,000.0, бусад 74,307.9, нийт 398,716.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэн, 106,849.5 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, машин, тоног төхөөрөмж тавилга зэрэг хөрөнгийг акталж үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 291,866.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв. /ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, ЗДТГ, ИТХ/

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,939.5 мянга, эцсийн үлдэгдэл 26,205.9 мянган төгрөг болж, 22,266.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой өглөг	367.5	823.4	455.9	2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	125.0	-125.0	-
Байгууллагад төлөх	1108.2	21,856.0	20,747.8	93.1
Хувь хүнд төлөх	509.8	0	-509.8	-
Татварын өглөг/ТӨҮГ/	875.5	3,401.4	2,525.9	4.8
Дансны өглөг/ТӨҮГ/	1,078.2	0	-1,078.2	-
Нийт дүн	3,939.5	26,205.9	22,266.4	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст байгууллагад төлөх өглөг 20747.8 мянган төгрөг буюу нийт өрийн 93.1 хувийг байгууллагад төлөх өр эзэлж байгаа нь ОНХСангаас гэрэлтүүлэг хийлгэсэн

5,200.0 мянга, ахуйн үйлчилгээний барилгын зураг төсөв хийлгэх үнэ 15,500.0 мянган төгрөг байна.

3.5.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,014,974.9 мянга, эцсийн үлдэгдэл 4,275,438.2 мянган төгрөг болж, 260,463.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,142,432.6	1,142,432.6	0	26.7
Хуримтлагдсан үр дүн	2,462,581.0	2,769,871.4	307,290.4	64.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	409,120.9	362,313.8	-46,807.1	8.5
Дүн	4,014,974.9	4,275,438.2	260,463.3	100

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Асгат сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Орлогын данс

Татварын болон татварын бус орлого 193.5 сая, орон нутгийн төсвөөс санхүүжилт 582.0 сая, улсын төсвөөс санхүүжилт 1,217.5 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 206.9 сая, борлуулалтын орлого 19.9 сая, хүү, торгуулийн орлого 6.7 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 344.9 сая, ЭМД сангаас 15.0 сая, нийт 2,586.6 сая төгрөгийн орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Борлуулалтын өртөг 73.6 сая, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,257.7 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 161.2 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 81.0 сая, хангамж, бараа материалын зардал 59.3 сая, нормативд зардал 162.1 сая, эд хогшил, урсгал засварын зардал 57.2 сая, томилолт, зочны зардал 2.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 92.7 сая, бараа үйлчилгээний бусад зардал 214.3 сая, бусад урсгал шилжүүлэг 74.3 сая, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 30.0 сая, үйл ажиллагааны бус зардалд 133.3 сая, нийт 2,399.5 сая төгрөг зардал тайлагнасан байна.

Зардлын данстай холбоотой холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй 1.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Хоолны зардлаас хэмнэгдсэн хөрөнгө нь төсвийн хэмнэлтэд тооцогдоогүй бөгөөд 1.0 сая төгрөгийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, хүнсний материал нөөцөлсөн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. /ЕБС/
- Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгож, төсвийг илүү зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон. /ЭМТ/

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 7 дугаар сарын 29-ны өдрийн 01 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 105.8 сая төгрөг, татварын бус орлого 5.0 сая, нийт 110.8 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр татварын орлого 200.3 сая

төгрөг, татварын бус орлого 4.7 сая төгрөг, нийт 205.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын гүйцэтгэл 185 хувь байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өссөн /Буурсан/
НИЙТ ТАТВАР ОРЛОГО			
	110.7	198.1	87.4
ТАТВАРЫН ОРЛОГО	105.7	193.5	87.4
Хувь хүний орлогын албан татвар	29.1	47.8	18.7
Үйл ажиллагааны орлого	0.6	0.2	-0.3
Хөрөнгийн орлого	20.0	25.0	5.0
Хөрөнгө борлуулсны орлого	0	5.7	5.7
Шууд бус орлого	8.5	16.8	8.3
Хөрөнгийн албан татвар	44.2	84.7	40.5
Бууны албан татвар	1.6	2.6	1.0
Малд ногдуулах албан татвар	42.6	82.1	39.6
Бусад татвар (төлбөр, хураамж)	32.4	60.9	28.5
Улсын тэмдэгтийн хураамж	1.9	0.1	-1.8
Байгалын ургамал ашигласны төлбөр	3.0	5.4	2.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.5	2.7	1.2
Газрын төлбөр	25.0	24.0	-1.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0	27.6	27.6
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	1.0	0.9	-0.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5.0	4.7	0.3
Хүү, торгуулийн орлого	5.0	4.7	-0.3

Орон нутгийн татварын болон татварын бус орлого төлөвлөснөөс 87.4 сая төгрөгөөр давсанд ан амьтны нөөц ашигласны төлбөр, малд ногдуулах албан татвар, шууд бус орлого, байгалийн ургамал ашигласны төлбөр, хөрөнгө борлуулсны орлого нөлөөлж байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 онд татварын орлогыг 205.5 сая, татварын бус орлогыг 5.0 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Засаг даргын хүргүүлсэн төсвийн татварын орлогыг 94.8 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Үүнд: Үйл ажиллагааны орлого, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого зэргийг бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 1,996.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,870.0 сая төгрөгийг урсгал зардалд, 76.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 50.0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 678.6 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,206.9 сая, Нийгмийн даатгалын сангаас 15.0 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 75.2 сая, нийт 1,975.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,931.1 сая төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдлийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Үүнд: Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төрийн болон орон нутгийн этгээдээс авсан хандив, тусламж 16.3 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 33.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 253.2 сая, нийт 306.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, урамшуулал, шимтгэлд 24.8 сая, бараа материалын зардалд 11.0 сая, нормативд зардалд 67.9 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 142.8 сая, томилолт, зочны зардалд 0.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 3.1 сая, урсгал шилжүүлэг 29.5 сая, нийт 284.5 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 0.9 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 156 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	-	-	0
Нийт	2	-	2	-	-	-	0

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн байгууллага 6, орон нутгийн тусгайн сан 2, эмийн эргэлтийн сан 1, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 67.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1.3 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.6 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15 зөвлөмжийг хүргүүлж, 45.8 сая төгрөгийн алдааг залруулсан.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Шилэн данстай холбоотой асуудал:

4.1.1 Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулгын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.1.2. Эрсдэл:

Төсвийн нээлттэй, ил тод, цаг хугацаандаа байх зарчим алдагдаж олон нийт мэдээллээр цаг хугацаандаа хамрагдахгүй байна.

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.2 Данс бүртгэлтэй холбоотой асуудал:

4.2.1 Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд мал амьтадын нас дэвшилт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг данс бүртгэлд бодит үнэ цэнийн аргаар толилуулаагүй нийтлэг алдаа гарсан байна.

4.2.2 Эрсдэл:

НББ-ийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийлэгдэх, Санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдэл зөрчигдөх

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.3.1 Илрүүлэлт:

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.3 /дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх/ заалттай нийцэхгүй байна.

4.3.2 Эрсдэл:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд дансанд хуримтлуулан бүртгээгүйн улмаас нягтлан бодох бүртгэлийн хяналтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна.

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх.

4.3.4 Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.НАРАНТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ДАВАА

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Б.ГАНЦЭЦЭГ